

ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ТУХАЙ ХУУЛЬДНЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Үндсэн хуулийн оршил хэсэг “Монголын ард түмэн бид:- улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж, -хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, -төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, -хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж, -эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно. Үүний учир Монгол Улсын Үндсэн хуулийг даяар олноо зарлан тунхаглаж байна.” гэж тунхаглан зарлаж, мөн хуулийн Долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монголын ард түмний түүх ... төрийн хамгаалалтад байна.” гэж хуульчилжээ.

Үндэсний их баяр наадам нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний эв нэгдэл, төрт ёс, түүх, соёл, өв уламжлал, зан заншлыг бэлгэдсэн үндэсний уламжлалт баяр бөгөөд 2003 оны 6 дугаар сарын 19-ний өдөр баталсан Үндэсний их баяр наадмын тухай хуулиар баяр наадмыг зохион байгуулах харилцаа хуульчилан зохицуулж байна. Үндэсний их баяр наадмын тухай хуулийг 2022 онд шинэчилэн найруулж дагаж мөрдөж байна.

Үндэсний их баяр наадмын хүрээнд үндэсний бөхийн барилдаан, сурын харваа, үндэсний хурдан морины уралдаан, шагайн харвааг зохион байгуулж байгаа бөгөөд Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт “Улсын баяр наадамд 10 жил тутам Их Монгол Улс байгуулагдсаны болон Ардын хувьсгалын тэгш ойг давхцуулан 1024 бөх, бусад баяр наадамд 512 бөх барилдана.” гэж заасан.

Энэхүү зохицуулалт нь 10 жил тутамд 1024 бөхийн барилдааныг Үндэсний их баяр наадмаар барилдуулж, цолны үнэлэмжийг дээшлүүлэх зорилготой боловч Ардын хувьсгалын тэгш ой тохиогоогүй боловч Их Монгол Улс байгуулагдсаны тэгш ой тохиолдох жилүүдэд 1024 бөх барилдах боломжгүй болгосон зохицуулалт юм. Уг зохицуулалтыг эргэн харж Их Монгол Улс байгуулагдсаны тэгш ой тохиолдох жилүүдэд 1024 бөхийн барилдаан зохион байгуулах асуудлыг Монгол Улсын төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч Ерөнхийлөгч тухай бүр шийдвэрлэдэг байх зохицуулалтыг бий болгох нь зүйтэй гэж үзэж байна.

Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн.” гэж, Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт “улсын цол, цэргийн дээд цол хүртээх, одон, медалиар шагнах;” гэж Ерөнхийлөгчийн үндсэн бүрэн эрх, мөн зүйлийн 4 дэх хэсэгт “Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрхийг зөвхөн энэ зүйлд заасан хүрээнд хуулиар олгож болно.” гэж заасан зохицуулалтуудтай нийцэж байгаа болно.

Түүнчлэн Их Монгол Улсын тулгын чулууг Их Эзэн богд Чингис хаан тавьж, дэлхийн түүхэнд газар нутгийг хэмжээгээрээ 2 дахь том гүрэн болж, өнөөдрийн ази европын 20 гаруй улсын нутаг дэвсгэрийн бүхэлд буюу тодорхой хэсгийг эрхшээн оршин тогтнож байсан билээ.

Түүнчлэн Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9 дэх хэсэгт “Бүх цэргийн баяр наадмыг жилд нэг удаа Засгийн газрын шийдвэрээр 256 хүртэлх бөх барилдуулахаар зохион байгуулж болно. ...зургаа давсан бөхөд цэргийн харцага... олгоно.” гэж заасан бөгөөд мөн зүйлийн 9.5 дахь хэсэгт аймгийн наадамд зургаа давсан бөхөд “аймгийн харцага” цол олгох асуудал орхигдсон байгааг нэмж оруулах шаардалага байна.

Үндэсний бөхийн спортоор хичээллэж буй хүүхэд, залуучуудын тоо тогтмол өсөж байгаа бөгөөд аймгийн баяр наадамд 16 насанд хүрсэн 128 хүртэлх бөх, аймгийн тэгш ойн баяр наадамд 256 хүртэлх бөх, сумын наадамд 64 хүртэлх бөх барилдуулахаар хуульчилсан байдаг. Энэхүү барилдах бөхийн тоог багаар тогтоосон нь үндэсний бөхийн спортоор хичээллэж буй хүүхэд, залуучуудын үндэсний их баяр наадмаар бүртгүүлж чадахгүй үлдэх, хасагдах, бүртгэл дагасан авлига, ашиг сонирхол, талцал, ялгаварлал гарах нэг шалтгаан болж байна.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн боловсруулж, холбогдо байгууллагаас саналыг авч байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Үндэсний их баяр наадмын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

-Хууль санаачлагч-

ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

2022 оны 7 дугаар сарын 01 өдөр баталсан Үндэсний их баяр наадмын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Ардын хувьсгалын 100, 101 жилийн ойг тохиолдуулан үндэсний бөхийн цолны маргаантай асуудлыг Монголын үндэсний бөхийн холбооны саналыг үндэслэн нэг зарчим, нэгдсэн журмаар холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий этгээд шийдвэрлэж болно.” гэж заасан боловч томьёолол нь ерөнхий байдлаас болж хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байна.

Түүнчлэн үндэсний бөхөөр барилдаж байсан тамирчин, тэдгээрийн гэр бүлийн гишүүдээс төрийн байгууллага, Үндэсний бөхийн холбоонд удаа дараа өргөдөл, хүсэлт гаргаж үндэсний бөхийн цолны маргаантай асуудлыг нэг удаа шийдвэрлэх асуудлыг хөндөн тавьдаг болно.

Иймд 2003 оны 6 дугаар сарын 13-ны өдөр баталсан Үндэсний баяр наадмын тухай, 2022 оны 6 дугаар сарын 28-ны өдөр баталсан Үндэсний баяр наадмын тухай хууль /шинэчилсэн найруулга/ батлагдаж хүчин төгөлдөр үйлчилэхээс өмнөх үеийн 1987 онд зохион байгуулагдсан Монголын бүх ард түмний спартакиад, 1995 оны Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр зохион байгуулсан “Өндөр Гэгээн Занабазарын 360 жилийн ойн баяр наадам, 1989 он, түүнээс хойших улсын баяр наадамд үзүүрлэж, шөвгөрсөн болон Ардын хувьсгалын тэгш ойн баяр наадамд шөвгөрч тухайн үеийн дүрэм, уламжлал, жишгийн дагуу цол олгогдох амжилт үзүүлсэн боловч цол нь олгогдоогүй бөхчүүдийн өөрийн, эсхүл гэр бүлийн гишүүний хүсэлтийн дагуу цолыг нөхөж олгох асуудлыг Монголын Үндэсний бөхийн холбооны саналыг үндэслэн Үндэсний их баярын наадмын хороо Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжлан нэг удаа шийдвэрлүүлэх болон Ардын хувьсгалын 100 жил, Залуучуудын байгууллага үүсэж хөгжсөний 100 жил, Монголын Үндэний бөхийн холбоо байгуулагдсаны 30 жил, Монгол бөхийг Дэлхийн дээд амжилт Гиннесийн номд бүртгүүлсэний 10 жилийн ойд зориулан 2021 онд зохион байгуулсан хүчит бөхийн барилдаанд 5, 6, 7, 8, 9 давж амжилт үзүүлсэн бөхчүүдэд Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 9.3 дахь хэсэгт цолыг Монголын Үндэсний бөхийн холбооны саналыг үндэслэн Үндэсний их баярын наадмын хороо Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжлан шийдвэрлүүлэх зохицуулалтыг тодорхой болгох шаардлагатай гэж үзэн хуулийн төслийг боловсрууллаа.

Цолыг нөхөн олгох зохицуулалтыг 2017 оны 2 дугаар сарын 09-ний өдөр баталсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлд “2017 оны 02 дугаар сарын 09-ний өдөр баталсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдахаас өмнөх жилүүдийн улсын баяр наадмын үндэсний сурын харваанд оролцож, тухайн хуульд заасан цолны болзлыг хангасан харваачид цолыг нөхөн олгоно.” гэж хуульчилж байсан байна.

